



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/304

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн суманд баригдаж байгаа "Хан Хэнтий чуулга"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Макс майнд" ХХК-тай байгуулсан УТБУ-01/2015 тоот гэрээг, мөн гэрээний сунгалтуудыг цуцлах болсонтой холбогдуулан бодит гүйцэтгэлтэй танилцаж гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Гантөгс	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	Б.Содбилэг	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Ганболд	-Мэргэжлийн хяналтын газрын Барилга, техник хяналтын улсын байцаагч
	Д.Батхуяг	-Мэргэшсэн төсөвчин /тохиролцсоноор/
	Г.Наранбаатар	-Барилгын төсөвчин /тохиролцсоноор/
	Д.Мөнхтулга	-Мэргэшсэн төсөвчин /тохиролцсоноор/

2. Улсын төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан эсэхэд дүгнэлт хийх ажлыг шуурхай зохион байгуулж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-т, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

